

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Л.НАСАНЦЭНГЭЛ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯМНЫ ХАРЬЯА  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Огноо: 2019.12.05

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛГААГ  
ОЛОН НИЙТЭД СУРТАЧЛАХ, МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ  
АЖИЛЛГААГ ОЛОН НИЙТЭД СУРТАЧЛАХ, МЭДЭЭЛЭЛ  
ХҮРГЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ  
ШАЛГАРУУЛАХ

Төслийн дугаар:

СЭМҮТ/201912012

Тендер шалгаруулалт/  
гэрээний дугаар:

СЭМҮТ-ТЕ-2019/15



## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019-12-05

Төндөр шалгаруулалтын нэр: СЭМҮТ-д Мэдээлэл сурталчилгааны үйлчилгээ  
гүйцэтгэгчийг шалгаруулах

Тендер шалгаруулалтын дугаар: СЭМҮТ/201912012

**Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааг олон нийтэд суртаслах, мэдээлэл хүргэх үйлчилгээг** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 төгрөгөөр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Удирдлагын байрны 210 тоот, Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга С.Ариунболд, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаас худалдан авч болно. Үнийн санал ирүүлэх үйлчилгээний загвар, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Удирдлагын байрны 210 тоот, Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга С.Ариунболд хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Удирдлагын байрны 210 тоот өрөөнд 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 11 цаг 30 минутанд нээнэ

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9 дүгээр хороо, 50 дугаар гудамж  
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Удирдлагын байрны 210 тоот,  
С.Ариунболд, 99039300



## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

### 1. Эрх Бүхий тендерт оролцогч

- 1.1. Тендерт оролцогч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээнд дэлжин авах тухай" хуулийн 14-16 дугаар зүйлд засан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 1.2. Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:  
**Шаардлагатай**
- 1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:
  - *Орон даяар өргөн сүлжээгээр цацдаг Бие даасан телевизийн байх*
  - *Олон жилийн туршлагатай /10 жилээс доошгүй байх/*
  - *Өмнө нь Эрүүл мэндийн чиглэлээр нэвтрүүлэг, төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай байх /гэрээний хуулбарыг ирүүлэх/*
  - *Өөрийн телевизийн байртай байх /зургаар баталгаажуулан ирүүлэх/*
  - *200 м.кв-аас дээш хэмжээтэй өөрийн студитэй байх /зургаар баталгаажуулан ирүүлэх/*

### 2. Тендерийн иж бүрдэл

- 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
  - (а) **Үнийн санал;**
  - (б) **Үйл ажиллагааны хуваарь;**
  - (в) **Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;**
  - (г) **Тусгай зөвшөөрөл шаардлагатай;**
  - (д) **Ижил төстэй ажлын гэрээний хуулбар 2019 он**
  - (е) **Ижил төстэй гэрээний үнийн дүн санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас доошгүй байх;**
  - (ё) **2019 оны II улирлын Санхүүгийн тайлан;**
  - (ж) **2019 оны Борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас доошгүй байх;**

- 2.2. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. Тендерийн үнэ
- 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарыт үндэслэнэ.
- 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдэж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
- 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Алдааг залруулах
- 5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дунд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дунг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
6. Санал  
Болгосон  
үнэ, түүнийг  
үнэлэх
7. Гэрээ  
байгуулах  
эрх олгох  
тухай  
мэдэгдэл
- 5.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хувагрийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### A. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- |  |  |   |  |
|--|--|---|--|
| 1. Гүйцэтгэгч<br>үйлчилгээ үзүүлэх   | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан үйлчилгээг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |   |  |
| 2. Төслийн<br>менежерийн<br>шийдвэр  | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |   |  |
| 3. Үйлчилгээ<br>дуусгахаар<br>төлөвлөсөн өдөр<br>үйлчилгээ дууссан<br>байх | 3.1. Гүйцэтгэгч үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан үйл ажиллагааны хуваарь болон төслийн менежерийн баталсан тодотгосон үйл ажиллагааны хуваарийн дагуу хийж гүйцэтгэн, үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |   |  |
| 4. Аюулгүй<br>байдал   | <table border="0"><tr><td style="vertical-align: top;">4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.</td><td style="vertical-align: top;">4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</td></tr></table> | 4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна. | 4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.              | 4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |   |  |
| 5. Зааварчилгаа  | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.  |   |  |
| 6. Маргааныг<br>шийдвэрлэх   | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |   |  |

## **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**

### **7. Үйл ажиллагааны хуваарь**

7.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны өрөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хуваарийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Үйл ажиллагааны хуваарийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь үйл ажиллагааны хуваарийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.

### **8. Зөрчил, гологдол илрүүлэх**

8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн үзүүлсэн үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа үйчилгээнд зөрчил, гологдол хайх, далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

### **9. Зөрчил, гологдол арилгах**

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

### **10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хуулийг баримтална.

арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

### 11. Үйл ажиллагааны хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарийн тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үйл ажиллагааны хуваарь нь үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үйл ажиллагааны хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

### 12. Үйл ажиллагааны хуваарийг өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр үйлчилгээний арга барил, эсхүл үйл ажиллагааны хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үйл ажиллагааны хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

### 13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## G. ГЭРЭЭГ ДУУСГАХ

### 14. Үйлчилгээ дуусгах

14.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер үйлчилгээ дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.

### 15. Хүлээж авах

15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0,05-0,10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

## 16. Эцсийн тооцоо

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

## 17. Гэрээг цуцлах

17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- (а) Үйл ажиллагааны хөтөлбөрт үйлчилгээ зогсоох тухай заагаагүй, түүнчлэн үйлчилгээ зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч үйлчилгээг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) төслийн менежер үйлчилгээний явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
- (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (е) гүйцэтгэгч үйчилгээний гүйцэтгэлийг гэрээний

тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

17.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч үйчилгээг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд челеелнэ

**18. Гэрээг  
цуцалсан үед хийх  
төлбөр**

18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн үйлчилгээний болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй үйлчилгээний гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн үйлчилгээ болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, үйлчилгээний зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**19. Гүйцэтгэлээс  
чөлөөлөх**

19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн үйлчилгээ болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.


## Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

- 2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар:  
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаа олон нийтэд суртачлах, мэдээлэл хүргэх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгох шалгаруулах СЭМҮТ/201912012
- 2.1 Ажил нь тендерийн баримт бичиг заасан тодорхойлолтыг хангаж, үе шатны хуваарийн дагуу хийгдэнэ.  
Ажлын хугацаа нь 1 жил байна
- 3.1 Төслийн менежер нь **СЭМҮТ-ийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн О.Батчимэг** байна.
- 4.1 Ажил эхлэх өдөр **2019.12.24**  
Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр **2020.12.24**
- 7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 9.1 Чанарын баталгаат хугацаа **365** хоног байна.
- 13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн **0,05 хувь** байна.  
Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн **5 хувь** байна.
- 19.1 Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын **0% -иар** тооцно.



<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

## Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



### 1. Сэтгэцийн эрүүл мэндийн алба үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн киног цацах

Нийт үргэлжлэх хугацаа 50 минут байна  
Телевизийн гарц, өнгөний нягтрал сайн байх  
Үзэгчдийн хандалт ихтэй цагаар цацах /19 цагаас хойш/

### 2. Сэтгэцийн эрүүл мэндийн албаны “Бид энэрэнгүй үйлстэн” сүлд дуунд клип бэлтгэх, цацах

Нийт үргэлжлэх хугацаа 4 минутаас багагүй байна  
Мэргэжлийн түвшинд клип бэлтгэх  
Клипийг хуулбарлаж захиалагч талд өгөх  
Захиалагч талаар хянуулах  
Телевизийн гарц, өнгөний нягтрал сайн байх  
Үзэгчдийн хандалт ихтэй цагаар цацах /19 цагаас хойш/


### 3. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх 1800-2000 утасны реклам бэлтгэх, цацах

Нийт үргэлжлэх хугацаа 20 секундээс багагүй байх  
Мэргэжлийн түвшинд Рекламыг /шторкыг/ бэлтгэх  
Рекламыг /шторкыг/ хуулбарлаж захиалагч талд өгөх  
Захиалагч талаар хянуулах  
Телевизийн гарц, өнгөний нягтрал сайн байх  
Үзэгчдийн хандалт ихтэй цагаар цацах /19 цагаас хойш/

### 4. Иргэдэд үнэ төлбөргүй сэтгэцийн зөвлөгөө өгөх төвийн реклам бэлтгэх, цацах

Нийт үргэлжлэх хугацаа 20 секундээс багагүй байх  
Мэргэжлийн түвшинд Рекламыг /шторкыг/ бэлтгэх  
Рекламыг /шторкыг/ хуулбарлаж захиалагч талд өгөх  
Захиалагч талаар хянуулах  
Телевизийн гарц, өнгөний нягтрал сайн байх  
Үзэгчдийн хандалт ихтэй цагаар цацах /19 цагаас хойш/

## Долоо. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ<sup>4</sup>



### 1. Сэтгэцийн эрүүл мэндийн алба үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн киног цацах

- Нийт үргэлжлэх хугацаа 50 минут байна
- Сэтгэцийн эрүүл мэндийн алба үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн киног 2020 оны 1-р улиралд багтаан Үзэгчдийн хандалт ихтэй цагаар 2 удаа цацах

### 2. Сэтгэцийн эрүүл мэндийн албаны “Бид энэрэнгүй үйлстэн” сүлд дуунд клип бэлтгэх, цацах

- Нийт үргэлжлэх хугацаа 4 минутаас багагүй байна
- Клипийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хийж дууссан байх
- Үзэгчдийн хандалт ихтэй цагаар 2020 оны 1, 2-р улиралд 10-аас дээш удаа цацах

### 3. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх 1800-2000 утасны реклам бэлтгэх, цацах

- Нийт үргэлжлэх хугацаа 20 секундээс багагүй байх
- Реклам, шторкийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хийж дууссан байх
- Үзэгчдийн хандалт ихтэй цагаар 10-аас дээш удаа цацах

### 4. Иргэдэд үнэ төлбөргүй сэтгэцийн зөвлөгөө өгөх төвийн реклам бэлтгэх, цацах

- Нийт үргэлжлэх хугацаа 20 секундээс багагүй байх
- Реклам, шторкийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хийж дууссан байх
- Үзэгчдийн хандалт ихтэй цагаар 10-аас дээш удаа цацах

<sup>4</sup> Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино. (Энэ бүлэгт нийтэд нь)

## Найм. Жишиг маягт

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[оёноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендэрийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендериин баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендериин баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендериийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг,  
тамга: \_\_\_\_\_

Албан тушаал, нэр:

Хаяг: \_\_\_\_\_

## 2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс :

Улсын төсвөөс: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай  
\_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_  
шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь,  
\_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_  
давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног  
төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ  
/дулаан, цахилгаан, цэвэр, бөхир усан хангамж/ \_\_\_\_\_  
туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны  
өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний өрөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт;  
Зураг;  
Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь<sup>5</sup>;  
Санхүүжилтийн хуваарь;  
Ажил гүйцэтгэх хуваарь;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>6</sup>.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

2. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

4. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

5. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

<sup>5</sup> Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

<sup>6</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]